



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
НЯМ-ОСОРЫН УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.06.23 № 41

Арвайхээрийн дулааны станцын
ажлын явцын талаар

Өвөрхангай аймгийн төвд 30 Гкал/цаг хүчин чадалтай дулааны станцыг анх 2018 оноос БНСУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барьж эхэлсэн ч тодорхой шалтгааны улмаас гүйцэтгэл нь 42 орчим хувьтай зогсож, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 18,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн ч төслийн үйл явц удаашралтай хэвээр байгаагаас иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх болон дулаан хангамжийн найдвартай байдал алдагдах эрсдэл үүсээд буй талаар нутгийн иргэд гомдол, мэдээлэл ирүүлж байна.

Тус станц ашиглалтад орсноор орон нутгийг найдвартай дулаан хангамж, хэрэглээний халуун усаар хангахаас гадна Арвайхээр хотын уурын зуухнуудыг буулгаснаар агаарын бохирдлыг 50 хувиар буурах ач холбогдолтой ажил юм.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Өвөрхангай аймгийн төвийн дулааны станцын төсөлд хуваарилсан 18,7 тэрбум төгрөгийн санхүүжилт графикайн дагуу олгогдож байгаа эсэх, одоогийн байдлаар гүйцэтгэгч компанид шилжүүлсэн санхүүжилтийн талаарх тоон мэдээлэл;

2.Дулааны станцын барилга угсралтын ажлын төлөвлөгөө, 2026 оны 6 дугаар сарын байдлаарх гүйцэтгэл, ашиглалтад бүрэн орох бодит хугацаа, холбогдох тайлбарын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, салбарын яамнаас тавьж байгаа хяналт, ажлын гүйцэтгэлд хууль тогтоомж болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцсон эсэх;

3.Арвайхээр сумын 5, 13 дугаар багийн уурын зуухнуудын хоёрдугаар хэлхээний шугам сүлжээг шинэчлэх 5,7 тэрбум төгрөгийн ажлын үр дүн, явцын талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



О.АЛТАНГЭРЭЛ

2026000119